

“Зүүн Хойт Ази хийгээд Монгол улс”

проф. Хэрээд Ж.Баясах *

ОРШИЛ

Монгол улс ардчиллын замд 1990 он гараад орсноос хойш зүүн Хойт Азийн орнуудтай ойртох чиг хандлагатай боллоо. Зүүн Хойт Азид манай хил залгаа Орос улсын Алс Дорнод хийгээд БНХАУ-ын Зүүн Хойт хэсэг багтдагаас гадна хоёр Солонгос улсууд хийгээд Япон улс ордог билээ.

Манай улс гадаад бодлогодоо хоёр хөрш зэргэлдээ улсуудтай найрамдаж хамтран ажиллахад тэргүүлэх ач холбогдол өгөхийн сацуу Зүүн Хойт Азийн орнуудтай өргөн харилцахад их анхаарч буй билээ.

Чингэхэд Зүүн Хойт Азийн бүс нутаг өнөөдөр ямар байгаа, цаашид кэрхэн өөрчлөгдөх тухай энэхүү өгүүлэлд тоймлон өгүүлэхийн хамт Монгол улсын хэтийн ирээдүйд яаж нөлөөлөх талаар төсөөлөн гаргахыг хичээсүгэй.

ЯПОН УЛС

Япон улс нь XX зууны эхнээс Дэлхийн II дайн дуустал Зүүн Хойт Ази хийгээд Зүүн Өмнөт Азид өөрийн ноёрхолыг тогтоохын тулд эзэрхэг түрэмгий бодлого явуулж ирснийг бид бүхэн мэдэх билээ. Иймээс ч энд хэд хэдэн улс Японы хараат болж, заримууд нь тухайлбал Хятад улс Японы түрэмгийллийн эсрэг бараг 20 жил дайн явуулсан бөгөөд зөвхөн Дэлхийн II дайнаар холбоотон гүрнүүд ялалт байгуулсны ачаар Японы Азид өөрийн ноёрголоо тогтоох гэсэн бодлого балран унасан юм.

Дайнд ялагдсан Япон улс хөл дээрээ босох гэж уйгагүй хөдөлмөрлөсний хирээр мөн АНУ-тай түншлэж эхлэсний ачинд 60-70-аад онд үсрэнгүй хөгжиж эхэлсэн бөгөөд дэлхийн хөгжингүй хоёр дахь улс болж Ази тивд “super-power” буюу “их гүрэн” болсон юм. Өнөөдөр Япон улс хэдийгээр дэлхийд хөгжлөөрөө хоёрдугаарт явж байгаа хэдий ч аж үйлдвэрийн өсөлт нь саарч, санхүү эдийн засаг нь хямарч “bubble economy” (үгчилбэл “бөмбөлөгөн эдийн засаг” Ж.Баясах)-ийн байдалтай болов.

* Хэрээд Ж.Баясах нь МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийн захирал, тус сэтгүүлийн зөвлөлийн гишүүн юм.

Тус улсын улс төрийн амьдрал ч төдийлөн сайнгүй байгааг өгүүлж буй нэгэн зүйл бол Дэлхийн II дайнаас хойш засгийн газрын тэргүүн - ерөнхий сайд хийгээд түүний кабинет 25 удаа солигдсон байна.

Япон улсын хувьд АНУ бол тэргүүн зэргийн түнш бөгөөд дайны дараа америк цэргийг өөрийн газар нутагтаа байрлуулж ирсэн юм. АНУ-ын хувьд Японд өөрийн цэргийг байрлуулснаар Ази тивийн зүүн биед өөрийн хяналтаа хадгалах болон хүчний харилцааг өөртөө ашигтай хувилбараар давамгайлж байдлаа хадгалахад стратегийн онцгой ач холбогдолтойг бид бүхэн мэднэ. АНУ нь Япон шиг баян, нөлөө бүхий улстай түншлэх нь онцгой болохыг тэр хоёр улс "XXI зуун руу хандсан стратегийн иж бүрэн түншлэл"-ийн 1996 онд тогтоосон пакт нотлон харуулсан юм.

Япон улс хэдийгээр Дэлхийн II дайны дараа зөвхөн "өөрийгөө хамгаалах" зэвсэгт хүчинтэй боловч орчин үеийн "өндөр технологи" (high-tech-зохиогч) эзэмшсэн, чамбай армитай, геополитикийн их чадавхитай улс хэвээр байна.

Япон улс ойрын жилүүдэд тогтвортой "гадаад орчин"-д оршиж байгаа хэдий ч Орос улсаас "хойт арлууд"-аа нэхсэн хэвээр, мөн БНХАУ-тай "Сенкакү ретто" буюу "Дяоюйдао" арлын маргаантай, түүнчлэн 1996 онд БНСУ-тай "Такэшима" буюу "Токто" арлаас болж хоёр улсын харилцаа хурцдаж ирсэн зэргийг онцлон дурдууштай. Түүнчлэн Тайваний асуудлаар АНУ болон БНХАУ-ын хооронд ширүүн маргаан үүсэхэд, тухайлбал 1996 онд Америкийн хөлөг онгоцууд Тайваний хоолойд дөхөн очиход БНХАУ-ын "Тайванийг бид хүч хэрэглэн чөлөөлөх эрхтэй" хэмээх ахуйд Япон улс өөрийн дуу хоолойгоо гаргаж чадахгүй буй нь өнөөгийн олон улсын харилцааны онолч нарын тодорхойлдог "сул гүрэн буюу хүч" (light power) болохоо харуулж байна.

СОЛОНГОСЫН ХОЙГ

Солонгосын хойгт эртнээс нааш солонгос туургатан оршин тогтнож ирсэн түүхтэй авч XX зууны эхээр Дэлхийн II дайн дуустал уг бүс нутаг харийн, тухайлбал Японы эрхшээлд орж, дараа нь өөр хоорондоо дайтаж

улмаар Өмнөт хийгээд Умарт хэсгүүдэд хуваагдан 1950-1953 онд өөр хоорондоо "иргэний дайн" явуулж, Умарт хэсэг нь Зөвлөлтийн талыг, өөрөөр хэлбэл "социалист" чиг баримжаатай БНАСАУ-улс болон харин Өмнөт хэсэг нь БНСУ-улс болон америкийг түшиж өнөөг хүрчээ. Солонгосын хойгийн асуудал "коммунист" ертөнц задарч, "хүйтэн дайн"-ы үе дуусмагц туйлын хүндэрч 1994-1996 онуудад БНАСАУ-ын цөмийн реакторын улмаас байдал ноцтой болж өнөөг хүрэв. Энэ хооронд АНУ-ын ерөнхийлөгч Б.Клинтоны анх 1996 онд "Солонгосын асуудал"-ыг дөрвөн талт хэлэлцээ хийх журмаар шийдэх санал дэвшүүлнээс хойш байдал янз бүрийн түвшинд яригдан, ялангуяа АНУ-ын "гурван төрлийн scenario буюу дэглэлт" хийх санал, тоочвоос:

- 1) soft landing-/үгчилбэл (онгоцоор бол) "зөөлөн газардах"-зохиогч/
- 2) implosion-/үгчилбэл гадны нөлөөгөөр дотроос нь "дэлбэлэх"-зохиогч/
- 3) explosion-/үгчилбэл "тэслэх"-зохиогч/ зэрэг нь онцгой анхаарал татаж байна.*

Энэхүү саналыг хураангуйлан өгүүлбэл: "soft landing" гэгч нь хоёр Солонгосыг энхийн замаар нэгтгэх, "implosion" бол БНАСАУ-ын хүнс тэжээл хомс, эрчим хүчээр гачигдаж буйг улам боогдуулж дотоодод нь "самуун" дэгдээн, "бослого" гаргуулан нурах, "explosion" нь дотоод, гадаадаас нь нөлөөлж БНАСАУ-улсыг унагах зэрэг болно.

Сүүлийн үед БНСУ-ын эдийн засаг, санхүү эдийн засгийн дампуурал, мөн ерөнхийлөгч асан Чон Ду Хван, Ро Дэ У нарын авилгалийн хэрэг, тэдний залгамжлагч асан ерөнхийлөгч Ким Ен Самын хүүгийн авилгал хийгээд нийгэм нь нийтдээ доройтсоноос болж Умарт, Өмнөт Солонгосыг энхийн замаар нэгтгэн, эхэн үедээ конфедераци буюу холбооны улс байгуулж хоёр талын суудалтай парламент ажиллуулж хоёр улсыг алхам алхамаар нэгтгэх "Өмнөт"-ийн санал зэрэг нь саарлаа.

* Уг саналыг 1996 оны 6-р сард Токио хотноо хуралдсан SNEAS-ийн (Зүүн Хойт Азийн Аюулгүй Байдлын) симпозиум явуулах үеэр АНУ-ын Төрийн нарийн бичгийн туслах Уинстон Лорд анх дэвшүүлсэн юм.

БНАСАУ нь хэдийгээр гадаад ертөнцийн хүмүүнлэгийн тусламжаар "хүнсний" асуудлаа бага багаар шийдэж байгаа ч улс ард нь "өлөн зэлмүүр" байдалтай, улс гэр нь "төрийн ноён нуруу"-гүй болоод 3 дахь жилийн нүүр үзэж байна.

Өнгөрсөн намраас "дөрвөн тал"-ын хэлэлцээ эхлээд Женевт, удаахь нь энэ жил Бээжинд явагдаж байгаа хэдий ч нааштай зүйл гараагүй хэвээр.

ЗҮҮН ХОЙТ АЗИ ХИЙГЭЭД ОРОС, ХЯТАД ХОЁР УЛС

Европ, Ази хоёр тивд газар нутагтай Оросын Холбооны улс нь М.С.Горбачев, Б.Н.Ельцин ерөнхийлөгч нарын үед, тодруулбаас "өөрчлөн шинэчлэл"-ээс 1995 он хүртэл Европын Холбоонд нэгдэх, мөн өрнөдийн ертөнцийн нэг хэсэг нь болох гэсэн гадаад бодлогоо, ялангуяа ГХЯ-ны сайдаар А.Козырев байхуй дахь "хоосон мөрөөдөл" нурсны дараагаар "virtual diplomacy" буюу "үнэнд нийцсэн дипломат ажиллагаа"-тай болсноор Орос улс дорно зүг рүү, ялангуяа Зүүн Хойт Ази руу илүү чиглэсэн гадаад бодлого явуулах болов. Иймээс Оросууд Японтой дахин гэрээ хэлцлийн ширээний ард сууж "хойт арлууд"-ын асуудлаа хөндөж, өнгөрсөн жил Японы ерөнхий сайд Р.Хашимототой ерөнхийлөгч Б.Н.Ельцин Сибирь нутагт улзсанаар хоёр улсын "уур амьсгал" зөөлрөх хандлагатай байна. Орос улс Солонгосын хойгийн асуудлаар шийдвэрлэх нөлөөгүй ч хааяа нэг "ам" гухуйлгах болсон. Харин БНХАУ-тай хоёр гурван удаа дээд хэмжээний улзалт хийж, харилцаагаа "стратегийн түншлэл"-ийн хэмжээнд хөгжүүлж байна.

БНХАУ улс нь Зүүн Хойт Азийн бүс нутагт өдөр ирэх тутам, ялангуяа онконгийг эх газартайгаа нэгтгэн авснаас хойш өөрийн нөлөөгөө улам бүр бататган байгаа, эдийн засаг нь бусдаас илүү хурдацтай, тогтвортой орон болж өөрчлөгдөж байна. Иймээс БНХАУ нь Зүүн Хойт Азийн хамгийн нөлөө үхий улс болж байна. Энэ байдал улам бүр батжин ирэх жилийн 12-р сарын 20-ны өдөр гадаад улсын харъяанд буй Хятадын сүүлийн газар нутаг

болох Макао (Аомынь - зохиогч)-г нэгтгэн авснаар Тайваний асуудал босч ирнэ. 1996 оны үйл явдал дэлхийн улс гүрнүүдээс зөвхөн АНУ л БНХАУ-ын эсрэг, Тайваний хямралыг сааруулагч хүчин болохоо харуулсан билээ. Иймд Тайваний асуудлыг зөвхөн АНУ, БНХАУ л шийднэ. Тайвань бол БНХАУ-ын хэсэг агаад, АНУ "түүний дотоод хэрэг"-т оролцохыг БНХАУ үл хүснэ. Саяхан БНХАУ-ын дарга Цзянь Цзэмин АНУ-д айлчлах үеэрээ Тайваньд "бид зэвсэг хэрэглэн хүчээр ч нэгтгэн авах эрх"-тэй болохоо мэдэгдсэн юм.

МОНГОЛ БА ЗҮҮН ХОЙТ АЗИ

Өмнө өгүүлсэнчлэн Монгол улс саяхнаар энэ бүс нутгийн хамтын ажиллагаа, үйл явцад оролцох болсон. Гэвч Монгол улс энэ бүс нутгийн үйл явцыг хараахан бүрэн дүүрэн ойлгож чадахгүй, хамтын ажиллагаа хийгээд интеграцын өрнөлийн төсөөлөл оролцоо бага, эдийн засгийн түншийн хувьд ядмаг байгаа учир, Монгол нь энэ бүс нутагт хамаарагдах эсэх, хэрхэн нөлөө бүхий этгээд болохоо тогтоогүй, мөн бүс нутагт нэрээ олоогүй цоо шинэ айл саахалт нь болой. Иймээс бид үнэхээр бүс нутгын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хэмээвээс, олон талт дипломат ажиллагаатай, өөрийн тодорхой чиг шугамтай, харилцагч талуудын ашиг сонирхлыг Монголд буй болгож, бүс нутгийн аливаа хямрал сөргөлдөөн үүдвэл хэрхэн хандах бодлоготой, мөн улс төрийн аливаа үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцогч болох нь чухал байна.

ДҮГНЭЛТ

Өнөөдөр энэ бүс нутагт Монгол улс нэр нөлөөгөө олоход таатай нөхцөлүүд хэзээний бүрэлдсэн гэж үзүүштэй, нэгд, Монгол улсын дотоод байдал нь тогтвортой, хоёрт, ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийг бүрдүүлж буй орон боллоо, гуравт, энэ бүс нутгийн нөлөө бүхий улс Япон, БНХАУ, ОХУ хийгээд БНСУ-тай харилцаа сайтай, дөрөвт, Япон хийгээд Солонгос туургатан монголчуудад удам судар, зүс царай, хэл заншил зэргээрээ элгэмсэг байгаагаараа олон талт харилцаанд таатай "ардын дипломат үйл ажиллагаа" буюу "public diplomacy" хөгжүүлэх хөрс байна.